



НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАГВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХОИЛЛОНГИЙН БАЙГУУЛЛАГА

“Ай Жэй Эй Эйч-Аудит” ХХК

2019 он 03 сар 14 өдөр

№ 72/2019

Улаанбаатар хот

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“БЭРХ УУЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигч танаа

Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

“БЭРХ УУЛ” ХК-ний 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, эдгээр санхүүгийн тайлангууд нь бүх материаллаг зүйлсийн хувьд “БЭРХ УУЛ” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартуудын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартуудын дагуу хүлээх хариуцлага энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бусаар ажиллах үүрэг хариуцлага бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэнд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайланд хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Зальт ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх, тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцооллыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна. Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлыг тодруулсан ба цаашид компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах үүрэг хариуцлагыг хүлээсэн байна.

Санхүүгийн тайлангийн талаархи аудиторын хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол гүйцэтгэсэн аудитын ажилдаа тулгуурлан эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах явдал юм. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг зөрчилгүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон мэргэжлийн ёс зүйн шаардлагуудыг даган мөрдөхийг биднээс шаарддаг.

Аудитын үед санхүүгийн тайлангууд дахь дүн мэдээ болон тодруулгын талаар аудитын нотолгоо олж авахад чиглэгдсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын шийдэлд суурилан сонгодог бөгөөд үүнд, залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийллийн эрсдлийн тооцоолол багтдаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхтэй холбоотойгоор, аудитор компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд нь дүгнэлт өгөх зорилгоор бус харин тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг тодорхойлохын тулд тухайн компанийн санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөвөөр илэрхийлэхтэй холбоотой дотоод хяналтыг авч үздэг. Түүнчлэн санхүүгийн тайлагналыг ерөнхийд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн томоохон тооцооллууд болон хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын ул үндэстэй бөгөөд тохиромжтой байдлыг үнэлэх ажлыг бидний аудит багтаасан. Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулах чадамжтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлсон.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компаний тухай хууль”-ийн 4-р зүйлд заасан хуулийн этгээд болох “БЭРХ УУЛ” ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ай Жэй Эй Эйч Аудит ХХК
Монгол улс, Улаанбаатар хот

Огноо: 2019.03.14

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

(мянган төгрөгөөр)

	Тэм	2017	2018
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	3	14,959.6	18,134.4
Авлага	4	144,605.7	88,439.2
Татвар, НДШ-ийн авлага	4	3,144.7	3,106.9
Бусад авлага	4	23,900.0	23,900.0
Бараа материал	5	10,724.5	6,538.9
Урьдчилж төлсөн зардал / тооцоо /			
Эргэлтийн хөрөнгийн дүн		197,334.5	140,119.4
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	6	2,445,015.2	2,330,834.2
Биет бус хөрөнгө	8	3,004.8	2,017.7
Хойшлуулсан хайгуул ба үнэлгээний хөрөнгө	7	9,378,638.4	9,377,796.4
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	9	2,267,630.7	2,267,630.7
Бусад эргэлтийн бус хөрөнгө		28,672.8	28,672.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		14,122,962.0	14,006,951.8
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		14,320,296.5	14,147,071.2
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	10	1,750,763.9	1,897,222.0
Цалингийн өглөг	10	248,995.6	248,995.6
Татварын өглөг	10	80,889.5	91,619.7
Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг	10	35,756.1	35,470.3
Хүүгийн өглөг	10	9,351,858.2	12,437,874.1
Урьдчилж орсон орлого	10	6,970.8	9,397.2
Богино хугацаат өр төлбөрийн дүн		11,475,234.1	14,720,578.9
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат зээл	11	12,502,247.3	13,602,776.3
Нөөц /өр төлбөр/	11	16,012,523.7	16,012,523.7
Урт хугацаат өр төлбөрийн дүн		28,514,770.9	29,615,300.0
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		39,990,005.1	44,335,878.9
Эздийн өмч			
Өмч / хувийн /	12	1,906,208.0	1,906,208.0
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	13	1,990,685.2	1,990,685.2
Хуримтлагдсан ашиг, (алдагдал)	14	(29,566,601.7)	(34,085,700.8)
Эздийн өмчийн дүн		(25,669,708.5)	(30,188,807.7)
Нийт өр төлбөр, өмчийн дүн		14,320,296.5	14,147,071.2

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ОРЛОГЫН ТАЙЛАН

2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

(мянган төгрөгөөр)

	2017	2018
Борлуулалтын орлого	1,148,739.0	1,149,016.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	971,151.6	932,000.8
Нийт ашиг (алдагдал)	177,587.4	217,015.8
Түрээсийн орлого	2,181.9	2,181.8
Хүүний орлого	522.7	377.8
Бусад орлого	4,340.0	69,000.9
Ерөнхий ба удирдлагын зардал	508,753.7	543,829.6
Санхүүгийн зардал	2,087,859.8	2,123,336.5
Бусад зардал	19,027.2	20,612.1
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	534,467.9	(2,143,599.2)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		23,739.7
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,896,540.9)	(4,519,061.4)
Орлогын татварын зардал	52.3	37.8
Татварын дараах ашиг (алдагдал)	(1,896,593.2)	(4,519,099.2)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(1,896,593.2)	(4,519,099.2)

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН
 2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

	(мянган төгрөгөөр)			
	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагд- сан ашиг	Нийт дүн
2017 оны 12 сарын 31	1,906,208.0	1,990,685.1	(29,566,601.7)	(25,669,708.6)
Гаргасан хувьцаат капитал				
Залруулсан үлдэгдэл				
Өмчид гарсан өөрчлөлт				
Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал			(4,519,099.1)	(4,519,099.1)
2018 оны 12 сарын 31	1,906,208.0	1,990,685.1	(34,085,700.8)	(30,188,807.7)

Нэмэлт тодруулууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг бол

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар

(мянган төгрөгөөр)

	2017	2018
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	1,260,205.4	1,361,090.3
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,259,662.5	1,283,916.3
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Бусад мөнгөн орлого	542.9	77,174.0
Мөнгөн зарлагын дүн (-)	(1,330,912.8)	(1,392,483.6)
Ажилчдад төлсөн	(402,815.1)	(374,227.5)
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(87,437.1)	(99,212.5)
Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
Ашиглалтын зардалд төлсөн	(11,108.8)	(10,349.8)
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(411,013.4)	(522,344.4)
Хүүний төлбөрт төлсөн	-	-
Татварын байгууллагад төлсөн	(145,613.9)	(153,236.0)
Даатгалын төлбөрт төлсөн		(296.5)
Бусад мөнгөн зарлага	(272,924.5)	(232,816.9)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(70,707.4)	(31,393.3)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	522.7	33,377.8
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	33,000.0
Хүлээн авсан хүүний орлого	522.7	377.8
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	522.7	33,377.8
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	318.7	1,190.3
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	500.0
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	318.7	690.3
Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	318.7	1,190.3
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(69,866.1)	3,174.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	84,825.6	14,959.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	14,959.6	18,134.4

Нэмэлт тодруулгууд нь эдгээр санхүүгийн тайлангийн салиггүй хэсэг болно.